

Хууль эрх зүйг шинэчилж байна гээд бусад нийгэм эдийн засгийн хөгжлийн болоод ёс заншлын асар өөр ялгаатай улс орны хуулийг шууд хуулбарлаж нутагшуулах гэж оролдох нь зохисгүй байх талтай.

Дээрх бүгдээс дүгнэхэд өнөөдөр манай улсад эрх зүйн шинэтгэл хэрэгтэй юу. үгүй гэвэл маш их хэрэгтэй тийм ч учраас Зөрчлийн тухай болон Гэмт хэргийн тухай хуулийг батлан гаргах тал дээр санал нэгдэж байна.

Өнөөдөр манай нийгэмд эрх зүйн шинэтгэлийг эсэргүүцэж, шүүмжилж байгаа нэг хэсэг байгаа, гэхдээ аливаа шинэчлэл эсэргүүцэл, шүүмжлэлгүйгээр шууд өөрчлөгдөн хувирвал нийгэм харин ч тэр чигээрээ аялдан дагалдагч болж, дарангуйлан ноёрхогч тал бий болсон гэж үзэж болно. Энэ утгаараа эсэргүүцэл, шүүмжлэл байна гэдэг бол Монгол Улсад ардчилал жинхэнэ утгаараа хөгжиж байгаагийн илрэл гэж үзэж байна.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн
821 дүгээр даижааны сонсогч,
цагдаагийн хошууч С.Гантулга*

МӨРДӨН БАЙЦААГЧ /МӨРДӨГЧ/-ИЙН ЭРХ ХЭМЖЭЭ ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН

Монгол Улс 1924 оны 11 сарын 26-ны өдөр анхдугаар Үндсэн хуулиа баталж тусгаар тогтносон бөгөөд бүрэн эрхэт, адил тэгш байдлын үндсэн дээр бусад оронтой найрсаг харилцаа тогтооход бэлэн гэдгээ дэлхий дахинаа тунхаглан зарласан. Энэ Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний талаар тусгахдаа “Тус улсын иргэн угсаа гарал, яс үндэс, нас хүйс, шашин шүтлэг, хөрөнгө чинээ үл харгалзан төрийн өмнө адил тэгш эрхтэй¹” гэж заажээ.

Шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотойгоор 1926 оны 04 сарын 16-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын гишүүдийн 15-р хурал, Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар “Аливаа шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай журам”-ыг баталж шүүх байгуулагдсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүн таслахаас өмнө “байцаагч түшмэл” гэгч албан тушаалтан гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдээс биеийн байцаалт, үйлдсэн хэргийн талаар тодруулан тодорхой байцаалтыг авдаг байсан байна. Гэхдээ “байцаагч түшмэд” нь цагдан сэргийлэх байгууллагын ажилтнаас тусдаа өөрийн тусгайлан харъяалсан гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг байсан байна.

Энэ хуулийн заалтаас харахад “байцаагч түшмэд” нь одоогийн мөрдөгч /мөрдөн байцаагч/-ийн ажлыг гүйцэтгэж байсан нь харагдаж байна.

¹ БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 11 дэх хэсэг.

1935 онд "Аливаа эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх тухай хууль"-ийг Улсын бага хурлаар батлуулан шинэчилсэн байна. Энэ хуулинд “Байцаагч түшмэд” гэх нэр томъёог өөрчлөн “байцаагч” гэж нэрлэн гус улсын дотор эрүүгийн хариуцлагад татах явдлыг үүсгэн мөшгөн байцаах үүрэг бүхий байгууллагыг тодорхойлжээ. Эдгээр нь:

1. Хууль хамгаалах прокурорууд ба тэдгээрийн байцаагч нар;
2. Үндэсний хувьсгалт цэргийн прокурорууд, тэдгээрийн байцаагч;
3. Сум ба хорооны нарийн бичгийн дарга нар;
4. Цагдан сэргийлэх газрууд¹ болохыг тодорхойлсон байна.

Улмаар 1949 онд БНМАУ-ын “Эрүүгийн хэрэг байцаан шийтгэх журмын тухай хууль”-ийг баталсан ба хуулийн 25-р зүйлд “Мөрдөн байцаагч - эдгээр нь аймаг, хотын прокурорын мөрдөн байцаагч, ахлах мөрдөн байцаагч, улсын прокурорын чухал хэргийн мөрдөн байцаагч, цэргийн прокурорын мөрдөн байцаагч, ДЯЯ-ны Улсыг аюулаас сахиж, хамгаалах газар ба улсын цагдан сэргийлэх газрын мөрдөн байцаагч нар болно^{1 2}” гэж анх удаа “мөрдөн байцаагч³” гэсэн нэр томъёо хуульд тусгагдсан байна.

2013 оны 7 сарын 05-ны өдөр УИХ-аас батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн 9 зүйлийн 9.1 дэх хэсэгт “Тэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах зорилгоор хууль сахиулах ажиллагаа явуулахыг гэмт хэрэгтэй тэмцэх гэнэ, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.15 дах хэсэг “Цагдаагийн алба хаагчид мөрдөгчийн зэрэг олгох” зэрэг заалтуудад “мөрдөн шалгах”, “мөрдөгч” гэсэн шинэ нэр томъёо бий болсон⁴.

Монгол Улсын УИХ-аас 2014 оны 01 сарын 16-ны өдөр батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулинд “Цагдаагийн албаны тухай хуулийн 20.1.15 дах хэсэгт заасан “мөрдөгч” гэсэн нэр томъёонд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан “хэрэг бүртгэгч”, “мөрдөн байцаагч” тус тус хамаарна гэж заасан байна⁵. Энэ бүхнээс дүгнэхэд “мөрдөн байцаагч” нэр томъёог орчин үеийн өндөр хөгжилтэй орны жишигт хүргэх шаардлагаар өөрчлөн “мөрдөгч” гэж хуульд тусгасан байна

Мөрдөх албаны тухай хуулийн төсөлд Мөрдөх албаны алба хаагч нь мөрдөгч, шинжээч мөрдөгч, кримналистикийн мэргэжилтэн, техникийн тусгай

¹ Аливаа эрүүгийн хэрэгт байцаан шийтгэх тухай хууль. 1 дүгээр зүйл.

² БНМАУ-ын Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1949.7.30-ны 4-р зарлигаар баталсан Эрүүгийн хэргийг байцаан шийтгэх журмын хууль. 25-р зүйл. 4 дэх хэсэг.

³ Орос хэлээр следователь-байцаагч, мөрдөн байцаагч, англи хэлээр investigator-мөрдөн байцаагч, мөрдөгч" гэх гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах үүрэг бүхий албан тушаалтан.

⁴ Цагдаагийн албаны тухай хуулийн 9дүгээр бүлэг. 9.1 дэх хэсэг, мөн хуулийн 20 дугаар зүйл. 20.1.15 дах хэсэг.

⁵ Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль. 8 дугаар зүйл.

ажилтнаас бүрдэнэ¹ гэснээс дүгнэхэд тусгай мэдлэгтэй шинжээч мөрдөгч, мөрдөгч гэсэн тодорхой чиглэлээр ажилдаг хууль сахиулагчид бий болж байгаа нь харагдаж байна.

Шинжээч мөрдөгч нь “хуульд заасан болзол, шалгуурыг хангаж, мөрдөгчийн тангараг өргөсөн, хууль сахиулах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, хууль сахилах ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий тусгай алба хаагчийг *шинжээч-мөрдөгч* гэнэ²” тодорхойлсон байна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дах хэсэгт "зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, *хэрэг бүртгэх, мөрдөн байцаах*, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, пгүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн нь төрийн тусгай алба хаагчид хамаарна^{3 4} гэж заасан байгаа тул мөрдөгч нь төрийн тусгай албан тушаалтаны хувьд тус хуульд заасан ниитлэг эрх, үүргийг хүлээнэ⁴.

Энэ байдлаас дүгнэхэд мөрдөгч нь хуульд заасны дагуу гэмт хэргийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах онцгой чиг үүрэг бүхий гэмт хэрэгтэй тэмцэх албаны ажилтан бөгөөд Монгол Улсын ЭБШХ-ийн 28 дугаар зүйлд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн эрх үүрэг, хийж гүйцэтгэх ажил, эрх хэмжээг тодорхойлж хуульчлан баталгаажуулсан байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж байгаа Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд “Гэмт хэргийг мөрдөх, зөрчлийг шалгах, нийгмийн хэв журам хамгаалах, аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж буй цагдаа, мөрдөх, маршал, шийдвэр гүйцэтгэх, хил хамгаалах, иргэний харьялал, шилжих хөдөлгөөн, онцгой байдлын албаны алба хаагчийг хууль сахиулагч гэнэ⁵” гэж тодорхойлсон ба энэ хуулийн төслөөс харахад мөрдөгч /мөрдөн байцаагч/ нь “хууль сахиулагч” гэсэн нэгдсэн нэрийн дор харьяалагдахаар байна.

Нэгэнт “хууль сахиулагч” гэсэн нэр томъёонд багтсан тохиолдолд “Хууль сахиулах үйл ажиллагааны журмын тухай хуулийн төсөлд заагдсан эрх, үүргийг хэрэгжүүлэхээр байна. Энэ хуулийн төслөөр хууль сахиулагч түүн дотроо мөрдөгч нь “Хууль сахиулах үйл ажиллагааны журмын тухай хуулийн төсөлд” заасан эрх үүргийн дагуу мөрдөн шалгах ажиллагааг явуулахаар байна. Энэ хуулийн төсөлд мөрдөгч заасан мөрдөн шалгах ажиллагааг явуулж болохоор тусгасан байна.

¹ Мөрдөх албаны тухай хуулийн төслийн 18 дугаар зүйл. 18.1 дэх хэсэг.

² Мөрдөх албаны тухай хуулийн төслийн 19 дугаар зүйл. 20.1 дэх хэсэг.

³ Төрийн албаны тухай хууль. 8 дугаар зүйл. Цахим эх сурвалж: www.legalinfo.mn

⁴ Төрийн албаны тухай хууль 13, 14 дүгээр зүйл.

⁵ Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль. 5дугаар зүйл. 5.1 дэх хэсэг.

Мөрдөгчийн үйл ажиллагаа бол хүний эрх, чөлөөнд хуульд заасан үндэслэл журмаар халдаж гэмт хэргийг илрүүлэх, шалгах тогтоох, онцгой үйл ажиллагаа юм. Мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангах тухай асуудал нь улс орны нийгэм эдийн засгийн тогтолцоо, эрх зүйн зохицуулалтын орчин, үндэсний түүх соёл, уламжлал, шашин шүтлэг, хүн амын амьдралын хэв маяг гэх мэт гадаад, дотоод орчны олон хүчин зүйлээс хамаарах бөгөөд түүнд төрийн байгууллагаас эхлээд төрийн бус, олон нийтийн бусад байгууллага ер нь нийгмийн бүхий л салбарын байгууллагын үүрэг чухал оролцоотой байж, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааны үр дүнгээр бодит биелэлээ олох ёстой.

Үүний дотор хууль сахиулах байгууллага тэр дундаа гэмт хэргийг илрүүлэх, шалгаж тогтоох, мөрдөн шалгах ажиллагаагаар хэргийн бодит үнэн байдлыг тогтооход чиглэсэн үүргийг хэрэгжүүлж байгаа мөрдөх албаны үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангахад нэлээдгүй зөрчил гарч, ард иргэдийн дунд ч тэдний үйл ажиллагааны шудрага, ил тод байдалд итгэх итгэл төдийлөн сайнгүй сэтгэл дундуур байгаа нь өнөөдөр нууц биш юм.

Нөгөө талаар гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгаж тогтоох уламжлалт арга, тактик өнөөгийн шаардлагад нийцэхгүй цаашлаад хуучин арга барилаар тэмцэх боломжгүй болж, харин уг ажиллагаанд бусад өндөр хөгжилтэй орны туршлагыг өөрийн орны онцлог нөхцөл байдалд тохируулан нэвтрүүлэх, шинжлэх ухаан, техникийн үсрэнгүй хөгжлийн ололт амжилтыг ашиглах явдал зүй ёсоор шаардагдаж байна.

Мөн үүнтэй зэрэгцэн эрх зүйн шинэтгэлийг хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж шинээр олон улсын жишигт нийцсэн хууль, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулан гаргаж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн бодит арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү нөхцөл байдлын үндсэн дээр мөрдөн албаны үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, түүний боломж нөхцөлийг бүрдүүлэх, хүний эрхийг зөрчихгүй байхад чиглэсэн бодитой ажлыг хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Иймд мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийг хангах, мөрдөх албадын харьяалал, бүтэц зохион байгуулалт, хоорондын уялдаа холбоог олон улсын жишигт хүргэхэд чиглэсэн асуудлыг цогц байдлаар нь судалж түүний үндсэн дээр эрх зүйн болоод бусад бүтэц, зохион байгуулалтын шаардлагатай арга хэмжээг шинжлэх ухааны судалгааны үндсэн дээр хэрэгжүүлэх нь өнөөдөр гэмт хэрэгтэй тэмцэх түүн дотроо шинэ төрлийн гэх гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагааны энэ тэргүүний зорилт болж цаашлаад гэмт хэрэгтэй тэмцэх Монгол Улсын төрийн нэгдсэн бодлогын үндэс, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлолх гол алхам болж байна.